

## ЗӨВЛӨЛТ—ЯПОНЫ ГАЗАР НУТГИЙН АСУУДАЛ

С. Ариунсанаа

Ази, Номхон далайн бүс нутаг, ялангуяа улс төр, эдийн засгийн чадавхийн хувьд тус бүс нутаг төдийгүй дэлхийн тавцнаа ихээхэн нөлөө бүхий болсон Зүүн хойт Азид итгэлцэл, энх тайван, аюулгүй байдал, үр өгөөжтэй хамтын ажиллагааг хангах чухал хүчин зүйлийн нэг бол энэ бүс нутгийн хөрш хоёр хүчирхэг гүрэн ЗСБНХУ (Одоо ОХУ), Японы хоорондын харилцааны асуудал юм.

Хэдийгээр дэлхийн II дайн дуусаад 47 жил, Зөвлөлт-Японы хооронд дайны байдлыг зогсоож хэвийн дипломат харилцаа тогтоосон хамтарсан тунхагт гарын үсэг зурснаас хойш 36 жил өнгөрч байгаа боловч тус хоёр хөрш гүрний хооронд энх тайвны гэрээ, хэвийн улс төр, эдийн засгийн харилцаа холбоогүй байж, тус бүс нутгийн олон улсын улс төрийн бодлого, улс хоорондын харилцаанд сөрөг нөлөө үзүүлсээр XXI зууны босгон дээр нэгэнт тулаан иржээ. Энэ нь Зөвлөлт-Японы хооронд байсан, байсаар байгаа газар нутгийн асуудалтай шууд холбоотой юм. Өнөөдөр хоёр улсын хооронд энх тайвны гэрээ, хэвийн улс төр, эдийн засгийн хэлхээ холбоог өргөжүүлэн хөгжүүлэхэд энэхүү шийдээгүй байгаа газар нутгийн асуудал саад болсоор байна.

Он удаан жил ЗХУ Японтой газар нутгийн асуудал байхгүй болохыг мэдэгдэж, энэ нь японы «хууль бус» шаардлага, бид зөвхөн 1905 онд Японд алдсан нутгаа 1945 онд буцаан авсан<sup>1</sup> гэсэн ойлголтыг өргөн олонд өгч, уг асуудлын талаар дэлгэрэнгүй авч хэлэлцдэггүй байлаа.

Бидний хувьд саяхан болтол тийм ч их тодорхой бус ойлголттой байсан энэхүү маргааны талаар зохих мэдэгдэхүүн олж авах явдал тус хоёр гүрний харилцааны тухай, түүний өнөөгийн нөхцөл байдлыг ойлгоход тус дөхөм болох болов уу.

Зөвлөлт-Японы газар нутгийн асуудлаархи бүтээлүүд өнгөрсөн түүхийн баримт, бүдүүвчээр дүүрэн байдаг. Хоёр тал аль аль нь өөр өөрсдийн Курилын арлуудтай түүхэн харилцаа холбооны давуу талыг батлан харуулах гэж зүтгэхдээ нөгөө талынхаа баримтуудыг үл тоон ач холбогдлыг нь бууруулахыг эрмэлздэг ажээ. Зөвлөлтийн нийтлэлүүдэд Курилын арлын түүх бол бүх арлыг нээж, суурьшиж, эзэмшсэн оросын эхлэн нээгч далайчдын гавьяа зүтгэл мэтээр тусгагдсан байдаг. Тэгвэл япончуудын үзэж байгаагаар Кунашир, Итуруп арал хэдийнээс японых байсан өөр хэнийх ч биш гэдэг байна.

Япончууд «хоппо рёдо» буюу «хойд газар нутаг» хэмээн нэрлэх болсон өмнөд Курилын арлууд болох Хабомай (102 кв. км), Шикотан (225 кв. км), Итуруп (1,138 кв. км), Кунашир (1,500 кв. км) дөрвөн арлыг 1855 оны 2 дугаар сарын 7-нд Симодод болсон Орос-Японы хооронд худалдаа, хөлөг онгоцоор зорчих харилцаа тогтоож, хоёр улсын хилийг тодорхойлсон анхны албан ёсны гэрээний дагуу Япон улс эзэмших болсон<sup>2</sup> гэжээ. Харин Сахалины арлыг хуваалгүй хамтын эзэмшилд үлдээсэн байна. Хожим удаан хэлэлцсэний эцэст 1875 оны 5 дугаар сарын 7-нд Санкт-Петербургт Курилын арлыг Сахалины арлаар сольсон Орос-Японы гэрээнд хоёр тал гарын үсэг зурж, Курилын арлыг Япон, Сахалиныг бүхэлд нь Орос эзэмших болжээ.<sup>3</sup>

С. Ариунсанаа —Зүүн хойт Ази судлалын төвийн эрдэм шинжилгээний ажилтан.

1904 онд Япон дайн зарлалгүйгээр Орост довтолон орж улмаар 1905 онд Портсмутын гэрээг байгуулахад хүрсэн ба уг гэрээгээр Орос улс Японд өмнөд Сахалиныг 50 градусын өргөргөөр өгсөн байна.<sup>4</sup>

1945 оны 2 дугаар сарын 4—11-нд болсон Крымийн бага хурал дээр ЗХУ, АНУ, Английн тэргүүн нар Алс дорнодын асуудлаархи гэрээнд гарын үсэг зурж, уг гэрээгээр ЗХУ Японы эсрэг дайнд орох тохиолдолд: «...2. 1904 онд Япон итгэлийг эвдэн довтолж зөрчигдсөн Оросын эрхийг сэргээх, Үүнд: а) ЗХУ-д Сахалины арлын өмнөд хэсэг, түүнд хамаарагдах арлуудыг буцаах, ...3. ЗХУ-д Курилын арлуудыг шилжүүлэх»-ээр тохиролцсон ба ЗХУ-ын дээрх шаардлага «Японыг ялсны дараа уг дуугүй биелэгдэх болно»<sup>5</sup> гэж тэмдэглэсэн байна. Ингээд 1945 оны 8 дугаар сард дээрхи гэрээний дагуу Японы дөрвөн арлыг авч тэнд амьдарч байсан япончуудыг нүүлгэн шилжүүлж, хот тосгоных нь нэрийг солин арлуудыг өмнөд Сахалины мужийн нэгэн хэсэг болгосон байна. ЗСБНХУ-ын Дээд Зөвлөлийн Тэргүүлэгчдийн 1946 оны 2 дугаар сарын 2-ны өдрийн зарлигаар өмнөд Сахалин, Курилын арлын бүх газар, түүний дээрхи болон доорхи бүх баялаг, усыг улсын өмч болголоо гэж тогтоожээ.<sup>6</sup> Энэ нь үнэн хэрэгтээ 1905 оны гэрээ, 1918—1922 оны Японы түрэмгийлэл, мөн 1938 оны Хасан нуурын орчим хийсэн Японы түрэмгийлэл зэрэгтэй холбогдуулан авсан хариу арга хэмжээ мэт ойлгогддог.

Дайны эхэнд эдгээр арлууд дээр 80-аад тосгонд 17 мянга гаруй япончууд амьдран сууж байжээ. Японы хэвлэлийн мэдээнээс үзвэл одоо Японд энд амьдарч байсан 10 гаруй мянган япончууд, тэдний хойч үеийнхэн байдаг ажээ.

«Ялтын гэрээ хууль эрх зүйн хувьд хүчин төгөлдөр бус юм, учир нь Япон улс бууж өгч байх үедээ дээрх гэрээний тухай мэдээгүй байсан», «1951 оны Сан-Францискогийн гэрээнд хэдийгээр Япон дөрвөн арлаас татгалзсан тухай тэмдэглэгдсэн ч уг гэрээнд ЗХУ гарын үсэг зураагүй учраас арлуудыг эзэмших ямар ч эрх тэдэнд олгогдоогүй»<sup>7</sup> гэх мэтээр японы тал үздэг юм байна. Гэвч асуудлын гол тогцоог цаашид улам гүнзгийрүүлэн судлуулштай юм шиг санагддаг.

1904—1905 оны Орос-Японы дайн, 1918—1922 оны Алс Дорнодод хийсэн түрэмгийлэл, 1938 онд Хасан нуурын орчим хийсэн үйлдлүүдээрээ Япон улс 1855, 1875 оны гэрээ болон бүх хэлэлцээрүүдийг үгүйсгэж байсан<sup>8</sup> төдийгүй дэлхийн II дайны үед Квантуны армийг зөвлөлтийн хил дээр байлгаж байсан нь Алс дорнодод манай 30—40 дивизийг байлгахад хүргэж<sup>9</sup>, Гитлерийн Германтай хамтран ажиллаж байсан учраас дайны дараа ялсан гүрнүүдийн боловсруулан тохирсон гэрээний дагуу л газар нутгийн асуудлыг шийдвэрлэх ёстой гэсэн байр суурийг зөвлөлтийн тал баримталсаар иржээ.

1950 оны 5 дугаар сард АНУ Японтой туслаа энх тайвны гэрээ байгуулахаар бэлдэж эхэлсэн нь угтаа ЗХУ, Японд шахалт үзүүлэх өөрийн гэсэн хөшүүрэгтэй болохын зэрэгцээ ирээдүйд явуулах америкийн бодлогод сонголт хийх ихээхэн бололцоо өөртөө үлдээхийг хичээж байсантай холбоотой юм.<sup>10</sup>

1951 оны 9 дүгээр сарын 8-нд Сан-Францискод болсон энх тайвны гэрээ байгуулах бага хурлын явцад Япон улс Курилын арлуудаас татгалзсан тухай гэрээнд гарын үсэг зурсан боловч дээрхи арлууд хэний эрх мэдэлд орсон хийгээд газар зүйн хил хязгаар нь тодорхой тусгагдаагүй хэмээн А. Громыко тэргүүтэй зөвлөлтийн төлөөлөгчид гарын үсэг зуралгүй бага хурлыг хаяж явсан нь угтаа Америк-Японы хооронд харилцан бие биенийн аюулгүй байдлыг хангах тухай гэрээ байгуулж, энэ гэрээний дагуу америкийн цэргийн бааз Японд үлдэх бол-

сон, БНХАУ-ыг уулзалтын ажиллагаанд оролцуулаагүй, мөн АНУ энх тайвны гэрээнд зөвлөлтийн талын гарын үсэг зурах зайг л үлдээсэн зэрэгт дургүйцсэн хэрэг байжээ. Тухайн үед ЗХУ америкийн цэргийг Японоос аль болох түргэн гаргахыг эрмэлзэж байсан аж. Гэвч Японтой хийсэн дайнаар бага бус хохирол үзсэн АНУ Японы газар нутаг дээр өөрийн цэргийн баазыг байлгах нь түүний Алс дорнодод явуулж байсан дипломат бодлогын гол зорилго болж байлаа.<sup>11</sup>

Энэ бага хурлын талаар «бидний хийх зүйл гэвэл гарын үсэг зурах л байлаа. Тэгээд л бүх юм хэвийн байдалд орчих байсан юм. Тэгсэн бол бид Японтой энх тайвны харилцааг сэргээж, Токио руу диплома-туудаа илгээж болох байсан. Гэтэл Сталин дураараа загнаж, Гэрээнд гарын үсэг зурахаас татгалзсан юм. ...Японтой байгуулах гэрээнд гарын үсэг зурахаас татгалзсанаараа бид америкчуудын занганд орж, эцэст нь АНУ-ын хамгийн түрэмгий, зөвлөлтийн эсрэг хүчинд тус хүргэсэн юм. Энэ бүхэн бидний өөрсдийн харалган байдлаас болсон хэрэг. Бид Японтой ямар ч хэлхээ холбоогүй байсан болохоор манай эдийн засаг, манай улс төрийн ашиг сонирхол хохирсон билээ»<sup>12</sup> гэж Н. С. Хрущев хожим өөрийн дурдатгалдаа бичсэн байдаг.

Сан-Францискогийн уулзалтын дараагаас эхлэн Япон нь биеэ даасан тусгаар тогтносон улс болж, олон оронтой дипломат харилцаа тогтоосон боловч ЗХУ-тай хууль эрхийн хувьд дайны байдлыг зогсоогоогүй байлаа.<sup>13</sup>

Сталинг нас барсны дараа ЗХУ Японтой харилцаагаа сайжруулах нь Алс дорнод дахь олон улсын байдлын чухал хүчин зүйлийн нэг гэж үзэж байсан тул харилцаагаа хэвийн болгохыг чухалчлах болжээ. Японд ч гэсэн улс төр, нийгэм, албаны болон худалдаа үйлдвэрлэлийн хүрээнд зөвлөлттэй хурдан харилцаагаа хэвийн болгохын төлөө хөдөлгөөн идэвхитэй өрнөх болсон байна. Ялангуяа загас агнуур, ой мод боловсруулах үйлдвэрийн газруудын төлөөлөгчид, Хоккайдо болон Хоншю арлын баруун эргийн боомт хотуудын оршин суугчид, Токио, Осака хотын албаны хүмүүс уг хөдөлгөөнийг идэвхтэй дэмжиж байлаа.<sup>14</sup>

1955 оны дунд үе хүртэл зөвлөлт-японы харилцаа тасарч, 1955 оны 6-р сарын 1-ээс хоёр улсын хоорондын хэлэлцээрүүд эхэлсэн ажээ. 1956 оны 10-р сарын 19-нд Москвад болсон уулзалтаар хоёр орны хоорондох дайн байдлыг зогсоож, хэвийн дипломат харилцаа тогтоосон хамтарсан Тунхагт Японы ерөнхий сайд И. Хатояма, ЗСБНХУ-ын Сайд нарын Зөвлөлийн дарга Н. Булганин нар гарын үсэг зурсан байна.

Японы Хабомай, Шикотан арлыг эргүүлэн өгөх тухай дээрх Тунхагт тусгагдсан байдаг. Үүнд: Хоёр тал газар нутгийн асуудлыг оролцуулан энх тайвны гэрээний талаар хэлэлцээрийг үргэлжлүүлэхээр гохирч, «гэхдээ ЗСБНХУ Япон улсын хүсэлт сонирхлыг харгалзан үзэж Хабомайн арлууд болон Шикотан арлыг Японд шилжүүлэн өгөхийг зөвшөөрч байгаа ба гагцхүү энэ арлуудыг ЗСБНХУ, Япон улсын хооронд энх тайвны гэрээ байгуулсны дараа жинхэнэ ёсоор шилжүүлэх болно»<sup>15</sup> гэж заасан байна. Мөн зөвлөлтийн тал, АНУ Окинава арлыг Японд буцаан өгсөн тохиолдолд<sup>16</sup> гэсэн нэмэлт нөхцөлийг тавьсан ажээ. Гэвч Япон улс дөрвөн арлаа зэрэг буцаан авна гэсэн байр суурь баримталсан бөгөөд хожим 1960 онд Япон улс АНУ-тай аюулгүй байдлын шинэ гэрээ байгуулсны учир ЗХУ дээрх амлалтаасаа буцжээ. 1960-аас 1970-аад оны эхэн үе хүртэл зөвлөлт-японы харилцаа урьд хожид байгаагүйгээр өссөн ба ялангуяа худалдаа-эдийн засгийн харилцаа идэвхтэй хөгжих болсон байна.

1973 оны 10-р сард Москвад хийсэн Японы ерөнхий сайд К. Танакагийн айлчлал зөвлөлт-японы худалдаа-эдийн засгийн харилцааны

хөгжилд шинэ түлхэц өгч капиталист гэгдэж байсан орнуудтай хийж байсан ЗХУ-ын худалдаанд Япон 1 байр эзлэх болжээ. Япон улс өмнөд Якутын коксжсон нүүрсний орд газрыг ашиглах, Алс дорнодын ой модны нөөцийг цаашид ашиглах болон Якутын байгалийн хийн орд газрыг судалж дуусгахад зориулж ЗХУ-д 1050 сая долларын удаан хугацааны банкны зээл олгох тухай тохирсон байна. Мөн 1975 оны 1 сард Токиод Сахалины нефть, хийг судалж олборлоход хамтран ажиллах тухай гэрээ байгуулжээ. Энэ бүхэн тус хоёр улсын худалдаа-эдийн засгийн харилцааг цаашид үр өгөөжтэй хөгжүүлэх өргөн боломжийг бий болгосон боловч энэ харилцаа удаан үргэлжлээгүй юм.

Япон улс 1972 оны 5-р сард АНУ-аас Окинава арлаа буцаан авсны дараа ЗХУ-тай газар нутгийн асуудлаа шийдвэрлэхийг эрмэлзэх болж, 1973 онд хийсэн дээд хэмжээний уулзалтад уг асуудлыг ихэд чухалчлан тавих болжээ. Удалгүй 1970-аад оны дунд үеэс эхлэн ЗХУ Япон улстай газар нутгийн ямар ч асуудал байхгүй хэмээн бүх шатандаа мэдэгдэх болсон юм. Ингээд 70-аад оны дунд үеэс 80-аад оны сүүл үе хүртэл зөвлөлт-японы харилцаа зогсонги байдалд орж хоёр тал аль аль нь энэ харилцааг мухардмал байдлаас гаргах арга замыг эрэлхийлээгүй бололтой.

Хоёр орны худалдаа жил ирэх тутам унаж, 1990 онд 2,8 хувь багассан бол 1991 онд 20 хувь хүртэл буурчээ. Одоо Японы гадаад худалдаа эргэлтийн ердөө л 1,1 хувь л ЗХУ (ОХУ)-д ноогдож байна.

Нэгэнт Москва газар нутгийн асуудал байхгүй тухай ярих болсон учраас хоёр улсын дээд хэмжээнд хийсэн уулзалтууд ч үр дүнгүй болж ёстой л «8 цагийн биш, 8 минутын харилцан яриа болдог байв. Япон өөрийн газрыг буцаан өгөхийг шаардаж, зөвлөлт ийм асуудал байхгүй гэж хэлээд л уулзалтын ажиллагаа дуусдаг байсан тухай М. С. Горбачёв Японд айлчилж байх үедээ хэлсэн байдаг.<sup>17</sup>

Газар нутгийн асуудал ингэж эргэсэн тул япончууд 1970-аад оны сүүлч 80-аад оны эхэн үеэс эхлэн улс орон даяараа «хойд газар нутгаа буцаан авахын төлөө» хөдөлгөөн, ухуулгын компанит ажлыг өргөн далайцтай өрнүүлэх болсон ажээ. Жил бүр 2-р сарын 7-ныг хойд газар нутгийн өдөр болгон орон даяар тэмдэглэх болж, энэ үйл ажиллагаанд хүн бүр оролцоод зогсохгүй ерөнхий сайд, консерватив намаас авахуулаад зүүний намуудын төлөөлөгчид идэвхтэй оролцох болсон байна. Энэхүү идэвхтэй үйл ажиллагааныхаа үр дүнд өнөөдөр Японд ямар ч нам, засгийн газар «хойд газар нутгаа буцаан авахын төлөө» хөдөлгөөнийг нэгэн дуугаар дэмжиж, уг хөдөлгөөн тус улсын гадаад бодлогыг бүрэлдүүлэгч нэгэн чухал хэсэг болон хувирчээ.

Токио «хойд газар нутгаа» бүрэн шилжүүлэн авсны дараа энх тайвны гэрээ байгуулах үндсэн дээр ЗСБНХУ-тай харилцаагаа сайжруулахыг чухалчлах болно гэсэн байр суурийг хатуу баримталсаар ирсэн юм. Үүнээс гадна «улс төр, эдийн засаг хоёр салшгүй» гэсэн зарчмыг зөвлөлттэй харилцах харилцаандаа албан ёсоор тунхаглаж, ардыг шилжүүлэхгүйгээр хоёр улсын хооронд эдийн засгийн өргөн хүрээтэй хамтын ажиллагаа байх бололцоогүй гэж мэдэгдэх болсон байна. Японы засгийн газар ч энэ зарчмынхаа дагуу ЗХУ руу чиглэсэн томоохон худалдаа наймааны эхлэл, удаан хугацааны эдийн засгийн гэрээ, санхүүгийн шууд туслалцаанаас эрс татгалзах болжээ.

Зөвлөлт-японы харилцааны хөгжилд саад тотгор болж ирсэн хэдэн хүчин зүйлүүд ажиглагддаг. Үүнд:

1 дүгээрт; «**Гуравдагч этгээд**» Ер нь орос-япон, зөвлөлт-японы харилцааны хөндийрлийг «гуравдагч этгээд» байнга өөрийн эрх ашигт ашиглаж ирсэн ажээ. Орос японы хоорондын үл итгэлцлийг XIX зууны

сүүлчээр солонгос, хятадын хаад, энэ зууны эхээр Лондон өөр өөрийн бодлогодоо идэвхитэн ашиглаж байжээ. Дэлхийн II дайны эхэнд Герман, Хятад, АНУ, Их Британы зарим бүлэг зөвлөлт-японы харилцааны хурцадмал бандлаас өөрсөддөө илэрхий ашиг хайж байлаа.

Курилын арлуудыг зөвлөлт эзлэн авсныг эхлээд Вашингтон, Бээжин санал нэгтгэнээр дэмжиж байв. 1945 онд Ялтад АНУ үүнийгээ баталж, хэсэг хугацааны туршид энэ байр сууриа хадгалсаар байсан бол арлуудыг эзэмших зөвлөлтний эрхийг Ялтад «соёлын хувьсгал» хүртэл дэмжиж байжээ. Харин эл хоёр улсын засгийн газар ЗСБНХУ-тай харилцаагаа муудангуут өөрсдийн дээрхи бодлогыг огцом өөрчилсөн юм.

Өнөөдөр Вашингтон, Бээжин Японы «хойд газар нутгаа» дахин эзэмшихийг дэмжиж байгаа хэдий ч энэ асуудлыг шийдвэрлэхийг төдийлөн хүсэхгүй байгаа юм.<sup>18</sup>

АНУ 1951, 1956 оны зөвлөлт-японы энх тайвны гэрээ байгуулах ажиллагааны үеэр Японд илт шахалт үзүүлсээр байсан юм.

Хоёрдугаарт; Үзэл сурталжсан улс төрийн бодлого. Үзэл суртал бол «коммунист» ба «чөлөөт ертөнцийн» улсуудыг сөргөлдүүлж байсан гол хүчин зүйл болж байлаа. Ялангуяа зөвлөлт-японы харилцаанд үзэл сурталжсан улс төрийн бодлого үйлчилж байсан явдал энэхүү харилцааны хөгжилд ихээхэн саад болж байсан юм.

Гуравдугаарт; Харилцан үл итгэлцэл. Зөвлөлт-японы харилцаанд энэ асуудал маш хурцаар тавигддаг. Японд «зөвлөлтийн аюул» гэсэн ойлголт хүн бүрийн сэтгэлд нэвт шингэсэн байдаг ажээ. Японы ямар ч номын дэлгүүрт Японы эргэн тойрон зөвлөлтийн цэргийн хүч ихсэж байгаа болон «хойд газар нутгийг» зөвлөлтийн цэрэг эзлэн авсан тухай ном тавиур дүүрэн байдаг байна. Хэрвээ японы түүхчид XIX зууны дунд үед Японд үзүүлж байсан англи, америкийн хүчний шахалтын тухай бичихдээ «түрэмгийлэл» гэсэн томъёог ихэвчлэн хэрэглэдэг бол оросуудын хувьд «сансёку» гэсэн тусгай хэллэг бий болжээ. Энэ нь «аажмаар эзлэн авах» гэсэн үгтэй утга дүйх аж.

Дэлхийн II дайны дараа болсон үйл явдал, түүний дараа, тухайлбал Сибирь, Алс дорнодод удаан хугацаагаар байлгаж байсан японы олзлогдогсодтой харьцаж байсан харилцаа зэргээс болж япончууд өнөөдрийг хүртэл ЗХУ-д хүйтэн ханддаг байна.<sup>19</sup> Энд тэмдэглэхэд японы 600 мянган олзлогдогсод 11 жил Сибирь, Алс дорнодод ажиллаж, тэдний 60 мянга нь тэндээ нас барсан байна. Харин 1990 онд япончууд өөрсдийн албан ёсны дүгнэлтдээ анх удаагаа «зөвлөлтийн цэргийн аюул» гэж дурдахаас татгалзсан байна.

1990 онд 10-р сарын 29—31-нд ТАСС, Киодо Цусин агентлагуудын явуулсан санал асуулгыг зорнод толилуулья гэж бодож байна. Зөвлөлтийн талаас асуугдсан хүмүүсийн 82,9% Японтой сайн хөршийн харилцаатай байхыг хүсдэг тухайгаа илэрхийлсэн бол япончуудын 42,4% энэ саналыг дэмжихээ илэрхийлж, 34,2% нь өөр бодолтой байна. Япончуудын 37-хон хувь ЗХУ-ыг энхийг эрхэмлэгч улс гэж үзэж байхад 49,9% нь энэ саналыг хуваалцаагүй байна. Санал асуулгад оролцсон япончуудын 3/4 нь ямар нэг хэмжээгээр зөвлөлтийн аюулыг мэдэрдэг гэж харнуулжээ. Харин ЗХУ-д санал асуулгад оролцсон хүмүүсийн 59,2% Японыг энхийг эрхэмлэгч гэж 15,5% эсрэг санал өгчээ.

Япончуудын 46% нь Курилын арлыг «нэгэн зэрэг буцаан авах»-ын төлөө саналаа өгч, 23,6% нь өөр ямар нэгэн санал илэрхийлсэн байна. Жишээлбэл: зарим нь 1956 оны Тунхагийн дагуу Хабомай, Шикотан арлаар л хязгаарлах, эсвэл шат дараалан арлуудыг буцаах, эсвэл НҮБ-ын мэдэлд юм уу зөвлөлт-японы хамтарсан удирдлагад шилжүүлэх саналтайгаа илэрхийлсэн байна. 4% өмнөд Курилыг эзэмшиж бай-

гаа одоогийн ЗХУ-ын байдлыг хүлээн зөвшөөрчээ. Зөвлөлтийн санал асуулгад оролцсон хүмүүсийн ихэнхи нь будлиантай газар нутгийн талаар бүх асуудлыг хангалттай мэдэхгүйгээс тодорхой байр сууриа илэрхийлсэнгүй. Харин зөвлөлт-японы хилийн одоогийн байдлыг хадгалахын төлөө 20,7% саналаа өгсөн байна.<sup>20</sup>

Дөрөвдүгээрт, Эдийн засгийн хамтын ажиллагааг харилцан өргөжүүлэхэд зөвлөлтийн өөрийн дотоодын бэрхшээлүүд нөлөөлсөн. Өөрийн хөрөнгөөр хамтарсан үйлдвэрийн газрууд нээсэн Японы худалдаачид зөвлөлтийн хууль тогтоомж, эдийн засгийн ерөнхий хямрал, рублийн ханш унаж байгаа зэргээс асар их алдагдалд орсон байна. Зөвлөлтийн тал хагас млрд. долларын төлбөрийг Японд төлж чадахгүй байдалтай болсон. Зөвлөлтийн мөнгөний хөрвөдөггүй байдал, үйлдвэрлэлийг удирддаг хүнд суртлын байдал, материал техникийн хангамжийн хоцрогдол, барилга байгууламжийг барих явц туйлын удаан, өндөр технологийн салбарт хамтын үйлдвэрлэл явуулах үндэс байхгүй зэрэг олон шалтгаанаас болж хамтын ажиллагаа урагш муутайхан байгаа ажээ. Үйлчилгээний салбарын үндсэн баазыг сайжруулаагүй цагт жуулчлалын талаар хамтын ажиллагааг хөгжүүлнэ гэдэг итгэхэд хэцүү л байна гэдгээ Гадаад орнуудтай соёлоор харилцах Японы нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга Кодзи Сугимори илэрхийлсэн байна.<sup>21</sup>

1980-аад оны дунд үеэс зөвлөлтөд эхэлсэн өөрчлөн байгуулалт Дорнод Европт хүчтэй өрнөж, улмаар 1991 он гэхэд Европын байдлыг үндсээр нь өөрчилсөн явдал зөвлөлт-америкийн харилцааг сайжруулан «хүйтэн дайны үе»-ийг эцэс болгож, зэвсэглэл хорогдуулах үйл явцыг улам түргэтгэх боллоо. Энэхүү үйл явцад Зүүн хойт Азийн бүс нутаг төдийгүй олон улсын амьдралд сөрөг нөлөө үзүүлж байсан зөвлөлт-японы харилцаа ч татагдан орох болсон юм. Дэлхийн II дайнаас хойш бүрэлдэн тогтсон олон улсын байдлын хуучин бүтэц нуран унаснаар Европ, АНУ руу чиглэгдэж байсан зөвлөлтийн гадаад бодлого харьцангуй сул хөгжсөн Алс дорнод руу, ялангуяа Зүүн хойт Ази руу хандах болов. Өөрчлөн байгуулалтын явцад зөвлөлтийн эдийн засаг гүнзгий хямралд орж, Бүгд Найрамдах Улсууд тусгаар тогтнох болсон явдал ОХУ-ын хувьд тус БНУ-ын ихэнх газар нутгийг эзэлдэг эдийн засгийн, байгалийн болон түүхий эдийн асар их нөөц бүхий Алс дорнодын районоа хөгжүүлэх зайлшгүй шаардлагыг бий болгоход хүргэсэн байна.

Олон улсын байдал ч асар хурдтайгаар өөрчлөгдөж, харилцааны шинэ систем бүрэлдэн тогтох болсон явдал тус хоёр гүрний хоорондын асуудлыг харилцан шийдэх арга замыг хайх, харилцаагаа мухардмал байдлаас гаргах гэсэн шинэ хүч эрмэлзлэлийг бий болгосон юм.

Олон жилийн турш цэрэг-улс төрийн биш, эдийн засаг-технологийн зарчим дээр тулгуурлан хөгжиж ирсэн Япон орны хувьд энэ харилцааны шинэ системд орж, хамтын ажиллагааны үйл явцад оролцоход дээд зэргийн бэлэн байдалд байгаа билээ.

Зөвлөлт-японы 300 гаруй жилийн харилцааны түүхэнд 1891 оны хавар «Память Азов» хөлөг онгоцоор хаан ширээ залгамжлагч хаан хүү Николай тухайн үедээ «дээд хэмжээнд» айлчилсныг эс тооцвол<sup>22</sup> анх удаагаа ЗСБНХУ-ын ерөнхийлөгч М. С. Горбачев 1991 оны 4-р сарын 16—19-нд Японд айлчилснаар зөвлөлт-японы харилцааг шинэ шатанд гаргалаа.

Энэ айлчлалаар ЗХУ анх удаагаа албан ёсоор хоёр улсын харилцаанд газар нутгийн асуудал байгааг зөвшөөрч, «Японы болон арлуудын оршин суугчдын харилцааг өргөжүүлэх зорилгоор японы иргэд визгүйгээр зорчих журам тогтоох, энэ районд хамтарсан харилцан ашигтай аж ахуйн үйл ажиллагааг эрхлэн явуулах, эдгээр арлууд дээр

байгаа зөвлөлтийн цэргийн тоог багасгах арга хэмжээнүүдийг ойрын үед хэрэгжүүлэх» тухайгаа мэдэгдсэн хэдий ч дөрвөн арлын асуудлаар оуулт хийгээгүй юм.

Харин япончуудын хувьд эртнээс итгэл найдвар тавин хүлээж байсан айлчлалын үр дүн тэдний санаанд төдийлөн нийцээгүй учраас зөвлөлтийн эдийн засагт үзүүлэхээр амласан ихээхэн хэмжээний санхүү-эдийн засгийн тусламжаасаа энэ удаа түдгэлзсэн юм. Ерөнхий сайд Т. Кайфу, түүний засгийн газрын зарим сайдууд айлчлалын үр дүнг газар нутгийн шаардлагыг хэрэгжүүлэх явц «алхам урагшиллаа» гэж өөдрөг сэтгэлээр дүгнэсэн байхад профессор Масамори, Сасэ, Хироши Кимура, Сигэки Хакамада зэрэг японы нэрт зөвлөлт судлаач, улс төрийн шинжээчид дээд хэмжээнд болсон айлчлалын үр дүнг «японы талын бүтэлгүйнх» гэж үзжээ. Учир нь зөвлөлтийн дээрх арга хэмжээнүүд дурдсан дөрвөн аралд зөвлөлтийн тавих бодит хяналтыг өчүүхэн ч сулруулаагүй юм гэжээ.

Зөвлөлтийн Бүгд Найрамдах Улсууд тусгаар тогтнон ЗСБНХУ гарцаагүй задрах болж, эдийн засгийн хямрал улам гүнзгийрэх болсон явдал Оросын Холбооны улсыг өөрийн эдийн засгийн хүчирхэг дорно хөрш рүү хандах хандлагыг улам идэвхжүүлсэн.

1991 оны 9-р сард ЗСБНХОУ-ын Дээд Зөвлөлийн даргын үүрэг гүйцэтгэгч Р. И. Хасбулатов тэргүүтэй Оросын парламентын төлөөлөгчид Японд айлчилж, Б. Н. Ельцины дэвшүүлсэн (1990 оны 1 сард, Японд С. А) зөвлөлт-японы харилцааг хэвийн болгох 5 шаттай төлөвлөгөөнд нэмэлт өөрчлөлт оруулж, үе шатыг хорогдуулах, хугацаа алдалгүй асуудлыг хурдан шийдэхийг японы талд санал болгосны зэрэгцээ оир хөрш орнууд, юуны өмнө японтой харилцах харилцааг хэлэлцээрийн үндсэн дээр биеэ даан шийдвэрлэх ба энэ харилцаа зөвхөн Горбачёваас биш, Орос болон түүний удирдлагаас шалтгаалах болсон тухайгаа мэдэгдсэн байна.<sup>23</sup>

Р. И. Хасбулатов энэ айлчлалынхаа явцад зөвлөлт, оросын удирдагчдаас анх удаагаа ЗХУ-тай харилцах харилцаандаа баримталж байсан японы бодлогын зарчмыг хүндэтгэн үзэж байгаагаа илэрхийлсэн юм.<sup>24</sup> Энэ зарчим нь дээр өгүүлсэн газар нутгийн асуудлыг шийдэхээс нааш өргөн хүрээтэй хамтын ажиллагаа, эдийн засгийн тусламж өгөхгүй гэсэн зарчим билээ. Тэрээр дээрх зарчмаа үл харгалзан эдийн засгийн хүчирхэг хөрш гүрнийхээ хувьд энэ хүнд үед нь Орост эдийн засгийн хямралыг даван туулахад зориулж 8—15 тэрбум долларын тусламж авах хүсэлтэйгээ илэрхийлжээ.

Энэ айлчлал япончуудад өөдрөг сэтгэл төрүүлсэн бөгөөд бүх асуудлыг авч хэлэлцэхэд бэлэн байгаагаа харну илэрхийлсэн байна. Японы засгийн газар 1990 оны 12 сард ЗХУ-д 100 сая долларын хүнсний болон эмнэлгийн яаралтай тусламж өмнөд Курилын дөрвөн арлын оршин суугчдад үзүүлэхээр шийдсэн шийдвэрийнхээ бодит алхам бол-

\* 1-р шат; ЗХУ, зөвлөлт-японы харилцаанд газар нутгийн асуудал байгаа гэдгийг албан ёсоор тодорхой хүлээн мэдэгдэх ёстой. Өнгөрсөн зууны дунд үеэс эхлэн түүний (газар нутгийн маргааны С. А) үүссэн түүхийн талаар шаардлагатай бүх мэдээллийг түгээх замаар асуудлыг «задалж» ЗСБНХУ-д аажмаар олон нийтийн санал бодлыг бүрдүүлэх шаардлагатай. Энэ шат 2—3 жил болно.

2-р шат; Өмнөд Курилын дөрвөн арлыг Японд үйлдвэр-худалдааны чөлөөтэй бүс болгон зарлах, түүнд (Японд С. А) дээд зэргээр тааламжтай нөхцөлийг бүрдүүлэх. Энэ шат 3—5 жил шаардагдана.

3-р шат; Арлуудыг цэрэг, зэвсэггүй бүс болгох, 5—7 жил үргэлжлэх байх;

4-р шат; ЗСБНХУ-Японы хооронд энх тайвны гэрээ байгуулж гарын үсэг зурах. Энэ дөрвөн шат нийлээд ойролцоогоор 15—20 жил болох ба үүний дараа 5 дахь шат эхэлж, Японд арлуудыг шилжүүлжнээр энэ шат дуусах эдгээр болно.

гож 1991 оны 12-р сард 20 сая иений (ойролцоогоор 150 мянган доллар) хүнсний тусламж олгохоор шийдсэн байна. Арлын оршин суугчдад их хэмжээний хуурай сүү, зайлшгүй шаардлагатай хүнсний бүтээгдэхүүнүүд өгөх ажээ.

Одоо Курилын арлууд дээр 20-нод мянган хүн амьдран суудаг. Шикотан арал гэхэд л 7 мянган оршин суугчтай юм байна. Зөвлөлтийн оросын) гаргаж байгаа бүх загасны консервын 4 консервын 1 нь Шикотаных байдаг бөгөөд жилд загасны үйлдвэрлэлээр 4 млрд, рублийн орлого оруулах боломжтой ажээ. Оросын загасан бүтээгдэхүүний нөөцийн 60% энд байдаг байна.

Хасбулатовын Японд хийсэн айлчлалын дараа Курилын болон Сахалины арлын оршин суугчид, эдгээр арлын удирдлагууд арлуудыг шилжүүлэхийг эсэргүүцсэн хөдөлгөөн байгуулж дөрвөн арлаа Японд өгөх гэсэн аливаа оролдлоготой тууштай тэмцэхээ мэдэгдээд ажил хаяхыг уриалж байлаа.<sup>25</sup> Энэ үеэр Москвад Японы элчин сайдын яамны өмнө Сахалин, Курилын оршин суугчдыг дэмжсэн, ОХУ-ын удирдлагын бодлогыг эсэргүүцсэн жагсаал цуглаан идэвхтэй хийжээ.

Сахалины мужийн губернатор В. Федоров 1991 оны 12 сарын эхээр өөрийн биеэр Японд айлчлахдаа Сахалины муж Хоккайдо арал дээр интеграцийн харилцааг түгээх, Ингэснээр хоёр мужийн эдийн засгийн болон нийгмийн амьдралыг ойртуулах, Курилын арлын бүсэд харилцан ашигтай хамтын ажиллагаа явуулах, бүх Курилын арал, Хоккайдо арлын хойд хэсгийг олон улсын байгалийн дархан цаазат газар болгон зарлах, Сахалин муж, Хоккайдод харилцан визгүй зорчих, ах дүүгийн холбоотой хотуудад визгүй зорчуулах гэсэн дөрвөн хувилбар бүхий өөрсдийн боловсруулсан саналаа танилцуулжээ. Гэвч эдгээр саналын алийг нь ч японы тал хүлээн аваагүй юм.<sup>26</sup> В. Федоров, ирээдүйн арлын хувь заяаны талаар японы талтай хийх бүх яриандаа «энэ арлууд манайх, манайх хэвээрээ үлдэнэ» гэсэн үүднээс л ярилцах болно. Газар нутгийн талаар буулт хийх тухай ярихын ч хэрэггүй. Хэрэв улс төрийн зүтгэлтнүүдээс хэн нэг нь Японд арлуудыг өгөхөөр завдах юм бол энэ нь улс төрийн амиа хорлож байгаа хэрэг. Үүнийг хүн бүр, тэр дундаа Ельцин ч ойлгох хэрэгтэй гэдгээ мэдэгджээ.<sup>27</sup>

Японтой харилцаагаа хэвийн болгох гэсэн Оросын засгийн газрын бодлого ийнхүү арлын оршин суугчид, түүний удирдлагын зүгээс ширүүн эсэргүүцэлтэй тулгараад байна.

Одоо Оросын Холбооны улсад энэ асуудлыг шийдэх дөрвөн хувилбар байгаа бололтой. 1-рт, юу ч хийлгүй энэ хэвээрээ байх, 2-рт хүсэж байгаа болгоныг нь өгөх, 3-рт «хоёр» арлаа шилжүүлээд үлдсэн хоёрыг Оросын мэдэлд үлдээх, 4-рт, НҮБ-ын хараа хяналтын дор арлууд дээр чөлөөт бүс байгуулах саналыг оролцуулан арлууд хэний мэдэлд байх тухай асуудлыг шийдэлгүйгээр янз бүрийн завсрын хувилбаруудыг хэрэглэх. Чухам эдгээрээс алийг сонгож авах нь Оросын ард түмний асуудал юм.

Ямар ч газар нутгийн асуудал хоёр талын ашиг сонирхлыг бүрэн хангахаар шийдэгдэнэ гэж байхгүй. Тийм учраас Оросын Холбооны улс ч тэр, Япон ч аль аль нь асуудлыг өнөөдөр дэлхий дахинд бүрэлдэн бий болоод байгаа олон улсын харилцааны шинэ нөхцөл байдлын шаардлагад тохируулан харилцан хүлээн авч болохуйцаар шийдэх нь юу юунаас ч чухал. Ингэх нь тус хоёр хүчирхэг гүрний ашиг сонирхол, Зүүн хойт Ази, Ази Номхон далайн бүс нутгийн орнуудын энх тайван, аюулгүй байдал, харилцан ашигтай хамтын ажиллагаанд ихээхэн нөлөө үзүүлэх олон талын ач холбогдолтой болох нь ойлгомжтой юм.

1. История СССР. Эпоха социализма. Под редакцией С. А. Сераева М, «Просвещение», 1977, с—349
2. Kodansha Encyclopedia of Japan. Vol. 8, p. 13
- 3, Мөн тэнд
4. Сборник договоров России с другими государствами (1856—1917). М., 1952, с—338.
5. Советский Союз на международных конференциях периода Великой Отечественной Войны. 1941—1945 гг. Крымская конференция руководителей трех союзных держав. —СССР, США, и Великобритании (4—11 февраля 1945). Сборник документов. М., 1979, Т. IV с—273
6. Ведомости Верховного Совета СССР. 1946. 8 февраля.
7. Ё. Прохоров. Л. Шевчук. О Территориальных претензиях японии к СССР» межд, жизни, январь, 1979 стр—47—53.
8. Б. Н, Славинский. На пути к советско-японскому мирному договору. Проблемы Дальнего Востока. № 1, 1990, с—137.
9. А. М. Василевский «Насан туршийн үйлс. УБ, 1978, х—591.
10. John J. Stephan. The Kuril Islands. p 217
11. Б. И. Славинский. На пути к советско-японскому мирному договору. Проблемы Дальнего Востока. № 1, 1990. с—140.
12. Н. С, Хрущев. Зөвлөлт -японы харилцааны тухай Цаг үе. № 11 (191) 1991. 13-р хуудас.
13. К. Нийдээки. Три волны в японо-советских отношениях. Проблемы дальнего востока. № 1, с—95, 1990.
14. С. Л. Тихвинский. Уроки дипломатических контактов. Проблемы дальнего востока, № с—93,
15. В. Головинн. Политические туманы над Курильскими островами Эхо планеты, № 15 (106), с—30-аас үзнэ үү.
16. К. Нийдээки. Три волны в японо-советских отношениях. Проблемы дальнего востока. № 1, 1990, с—96
17. Пресс конференция М. С. Горбачева в Токио. «Известия» 20 апреля 1991.
18. Дж. Стэфан. От какого наследства надо отказаться? Новое время, № 32, 1990. с—8
19. Минору Такахаси. Когда исчезают преграды. Известия, 23 августа 1990.
20. Советско-японские отношения. Известия, 25 ноября 1990.
21. Кодзи Сугимори. Сценарий для двух актёров, или закулисами запланированного визита. Новое время, № 3, 1990.
22. К. Саркисов. Вызов времени; советско-японское отношения на пороге нового века Известия, 1 сентября 1990.
23. Руслан Хасбулатов; Орос улс Японтой найрамдлын гэрээ байгуулж, нутаг дэвсгэрийн асуудал зохицуулах зориг төгс байна, МОНЦАМЭ, 1991 оны № 211, 6-р хуудас
24. В, Овсянников. С кем вести разговор, Новое время, № 38, 1991. с 23
25. Зөвлөлтийн арлуудыг Японд өгөхийг эсэргүүцэв. МОНЦАМЭ, 1991 оны № 226. 7-р хуудас
26. И. Латышев. Дело всей России. Правда, 6 декабря 1991.
- 27, Мөн тэнд.